



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/06/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН
ТӨВИЙН ДАРГА Б.БАХЫТГҮЛ
ТАНАА

2022.02.16 № 65
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,124,838.00	90,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	1,034,838.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	90,000.00	90,000.00
354	Хангамжийн материал	90,000.00	90,000.00
35420	Аж ахуйн материал	90,000.00	90,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	553,333.00	20,401,261.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	553,333.00	20,401,261.00
392	Биет хөрөнгө	553,333.00	20,401,261.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	560,000.00	30,370,883.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(426,667.00)	(11,764,808.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	550,000.00	12,327,041.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(130,000.00)	(10,531,855.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,678,171.00	20,491,261.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	868,500.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	868,500.00	-
413	Өглөг	868,500.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	811,000.00	
4136	Бусад өглөг	57,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	57,500.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	809,671.00	20,491,261.00
51	Засгийн газрын хувь оролцоо	809,671.00	20,491,261.00
512	Хуримтлагдсан үр дүн	809,671.00	20,491,261.00
51210	Өмнөх үеийн үр дүн	809,671.00	809,671.00
51220	Тайлант үеийн үр дүн		19,681,590.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,678,171.00	20,491,261.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,000,000.00	75,053,170.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,000,000.00	75,053,170.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	75,053,170.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		26,993,870.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		48,059,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,000,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,000,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	57,450,911.00	55,371,580.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,450,911.00	55,371,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,298,978.00	54,242,034.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,643,067.00	41,444,551.00
210101	Үндсэн цалин	46,643,067.00	41,444,551.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,066,911.00	5,651,541.00
210201	Тэтгэврийн даатгал	4,066,911.00	5,651,541.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	589,000.00	7,145,942.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	195,000.00	7,145,942.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,151,933.00	1,129,546.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,151,933.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,151,933.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,129,546.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,129,546.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,549,089.00	19,681,590.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,549,089.00	19,681,590.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			(1,739,418.00)		(1,739,418.00)
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(1,739,418.00)	-	(1,739,418.00)
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			2,549,089.00		2,549,089.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	809,671.00	-	809,671.00
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,358,760.00	-	3,358,760.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	809,671.00	-	809,671.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			19,681,590.00		19,681,590.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	20,491,261.00	-	20,491,261.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	60,000,000.00	48,059,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,000,000.00	48,059,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	48,059,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		48,059,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,000,000.00	-

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,000,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	59,700,000.00	48,059,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,700,000.00	48,059,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,548,067.00	46,929,754.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,454,067.00	41,278,213.00
210101	Үндсэн цалин	47,454,067.00	41,278,213.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,700,000.00	5,651,541.00
210201	Тэтгэврийн даатгал	3,940,000.00	3,957,841.00
210202	Тэтгэмжийн даатгал	440,000.00	423,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	352,000.00	338,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	88,000.00	84,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	880,000.00	846,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,151,933.00	1,129,546.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,151,933.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,151,933.00	
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,129,546.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,129,546.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	300,000.00	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	300,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	300,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	300,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	300,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(300,000.00)	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,059,300.00	46,929,754.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,059,300.00	46,929,754.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,059,300.00	46,929,754.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,343,000.00	41,278,213.00
210101	Үндсэн цалин	42,343,000.00	41,278,213.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,716,300.00	5,651,541.00
210201	Тэтгэврийн даатгал	4,022,600.00	3,957,841.00
210202	Тэтгэмжийн даатгал	423,400.00	423,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	338,700.00	338,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	84,700.00	84,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	846,900.00	846,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,059,300.00	46,929,754.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,059,300.00	46,929,754.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	48,059,300.00	46,929,754.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй байна

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Насан туршийн боловсролын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Насан туршийн боловсролын төв нь Орон нутгийн иргэдийн боловсролын түвшинг судалж, санал дүгнэлт боловсруулах, сургалт зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийсэн байна

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 57.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1034.8	0	-1034.8
Урьдчилгаа			
Бараа материал	90.0	90.0	0
Үндсэн хөрөнгө	553.3	33962.1	33408.5
Нийт хөрөнгө	1678.2	34052.1	32373.9

Өр төлбөр	868.5	0	-868.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	809.7	34052.1	33242.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1678.2	34052.1	32373.9

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна. Авлага данс оны эхэнд 1.0 төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд авлагын бүрэн барагдуулсан байна. Бараа материалын дансны үлдэгдэл 0.09 сая төгрөг байгаа бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 34.0 сая төгрөг болж 32.4 сая төгрөгөөр өссөн нь 2021 оны 03 сарын 05-ны өдрийн аймгийн Засаг даргын А/177 тоот захирамжаар Орон нутгийг хөгжүүлэх сангаас нийт 8.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг өнгөт принтер авсан байна. Мөн Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр БСШУСайдын 2020 оны А/200 тоот тушаалын хүрээнд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох онлайн танхим” байгуулагдсан бөгөөд 19.0 сая төгрөгийн нийт 18 нэр төрлийн тавилга, тоног төхөөрөмж, ном гарын авлага нийлүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын 124 тоот “Балансаас балансад хөрөнгө шилжүүлэх” тогтоолоор нийт 15.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Өлгий сумын 4 дүгээр сургуулийн балансаас шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант оны эхэнд 0.9 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд өглөгийг барагдуулж ажиллажээ.

Тайлант хугацаанд өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 34.0 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 33.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 48.1 сая төгрөг байна. тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 48.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 46.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төсвийг нийт дүнгээр 1.1 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Цалингийн зардлыг 1.1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.06 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Насан туршийн боловсролын төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Насан туршийн боловсролын төв нь 2021 онд нийт 8 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 8 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн аудитаар 2.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд албан шаардлага болон зөвлөмжийн биелэлтийг Насан туршийн боловсролын төвийн 2021.05.17 №27 тоот албан бичгээр ирүүлжээ.

Гарсан зөрчлийг арилгаж татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг барагдуулан, цалингийн зардлын төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулав.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд дараах залруулга Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан, Санхүүгийн байдлын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан тус тус хийгдсэн болно.Үүнд:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор Өлгий сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулиас үндсэн дансанд бүртгэлтэй 24 нэр төрлийн 14.6 сая төгрөгийн хөрөнгийг балансын үлдэх өртөггүй, элэгдлээ бүрэн нөхсөн тоног төхөөрөмж, тавилгыг шилжүүлж данс бүртгэлд тусгахдаа хуримтлагдсан элэгдлийг данс бүртгэлээс орхигдуулсныг залруулав

2. БСШУЯ болон Азийн Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтаар “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд нийлүүлсэн 7 ширхэг ширээний үнийг тайлан балансад 1.0 сая төгрөгийн зөрүүтэй тусгасныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Насан туршийн боловсролын төв	2	15.6	2	15.6						